

Т.Баярцэцэг

МУИС-ийн Социологи, Нийгмийн ажлын тэнхмийн багш

УУЛ УУРХАЙН КОМПАНИУД БА ОЛОН НИЙТ: БИЗНЕСИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГААР ОРОН НУТГИЙН ИРГЭДИЙН ЧАДАВХИЙГ САЙЖРУУЛАХ НЬ

Abstract: Development and effective implementation of the corporate social responsibility (CSR) plan are now becoming an important prerequisite for operating mining in local areas with fewer complications. Despite the fact that one time activities or grants are mostly planned under the social responsibility plan, more actions, programs and plans with sustained results are in demand. Such confluent plans will have effects both on improved company reliability and increased local capacity. Nevertheless, mining companies do not pay much attention to its public relations and likely to dedicate small chunk on the implementation of the CSR. On the other side of the coin, another wrong tendency exists that local community members urge mining companies to provide every single item asked for. This is why it is becoming critical to find the edge where mining companies and the community could collaborate on development and implementation of the CSR plan locally.

Key words: Corporate social responsibility, community development, sustainability, community capacity, social capital

Оршил

Бизнесийн байгууллагуудын үйл ажиллагаа өргөжин тэлж буй нь бидний өдөр тутмын амьдралд сайнаар нөлөөлж байгаа гэдэгтэй хэн ч эргэлзээгүй санал нийлэх буй заа. Бизнесийнхэний “буянаар” ажлын байр нэмэгдэж, улсад төлөгдөх татварын хэмжээ өсч, иргэдийн орлогын эх үүсвэр өсөн нэмэгдэж, цаашлаад тодорхой хүрээнд хүмүүс чадавхиж байгаа нь сайшаалтай. Ялангуяа манай улсын эдийн засагт уул уурхайн компаниудын оруулж буй хувь нэмэр их байгааг хэн бүхэн мэднэ.

Нөгөө талаар хүний үйл ажиллагаанаас болж зөвхөн манай улс гэлтгүй дэлхий даяараа нөөцийн хомсдолд өртөж, бизнесийн орлого тэгш бусаар хуваарилагдаж тухайн улс орны соёл, ёс заншил биенест дарагдах явдал цөөнгүй тохиолдсоор байна. Сүүлийн үед бизнесийн байгууллагын нийгмийн хариуцлага нэрийн дор их зүйл хийгддэг болсон боловч тэдгээр нь тэр бүр дээр дурдсан сөрөг нөлөөллүүдийг соргогоор ажигласан, үйл ажиллагаа явуулж буй орон нутгийн иргэдийн амьдралд нөлөөлөхүйц тогтоцтой арга хэмжээ байж чадахгүй байгаа юм. Компанийн нийгмийн хариуцлага гэдгийг бид хэрхэн ойлгодог вэ? Өөрийн компанийн боловсон хүчнийг бэлтгэх зорилгоор сургалт зохион байгуулж, хүүхдийн цэцэрлэгээр айлчлан үйлдвэрлэсэн хүнсний бүтээгдэхүүнээ тараах нь нийгмийн хариуцлага амжилттай хэрэгжүүлж буйн жишээ мөн гэж үү? Нөгөө талын ер нь бизнесийн байгууллага бүр, тэр дундаа уул уурхайн компаниуд үйл ажиллагаа явуулж байгаа орон нутгийн байгаль, иргэдийн аж байдалд яагаад санаа тавьж байх ёстой юм бэ?

Дэлхийн банкны шугамаар хөгжиж буй орнуудад судалгаа хийсэн МасПэйл болон Дэви нар (McPhail & Davi, 1998) хэд хэдэн оронд үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн компаниудын нийгмийн болоод байгаль орчны нөлөөллийн үнэлгээг харьцуулан авч үзээд дараах нийгмийн асуудлууд нутгийн иргэдийн амьдралд сөргөөр нөлөөлж байна гэж үзжээ. Эдгээр нь:

- Уул уурхайгаас орж ирэх их хэмжээний хөрөнгө оруулалтын нийгэм, эдийн засгийн эрсдэлийн дутуу тооцох явдал. Тухайлбал хөрөнгө оруулалт тухайн орны соёл, ёс заншил хэрхэн нөлөөлж болох, нийгмийн эмзэг бүлэг хөрөнгө оруулалтын ашиг тусыг хэрхэн тэгш хүртэх, байгалийн баялагаа нутгийн иргэд хэрхэн өөрсдөө ашиглаж болох гэх мэт асуултын хариуг олж чадалгүй хоцрох явдал их тохиолддог;

- Олон нийтийг хөгжүүлэх үйл ажиллагааг засгийн газрын болон компанийн нийгмийн хариуцлагын төлөвлөгөөнд уялгүй орхигдуулах явдал. Жишээ нь ундны цэвэр усны хангамж, орчны ариун цэврийн асуудал, олон нийтийн эрүүл мэнд, боловсрол гэх мэт асуудлыг нийгмийн хариуцлагын төлөвлөгөөнд тусгаагүй байх нь тохиолдоно;
- Уул уурхайн хөрөнгө оруулалтыг нийгмийн дэд бүтцийг хөгжүүлэхэд чиглүүлж, олон нийтийн оролцоо, түншлэл болон олон нийтийн чадавхийг бэхжүүлэх замаар хөрөнгө оруулалтын урт хугацааны, тогтвортой үр нөлөөг хангахад анхаарахгүй байх явдал;
- Хүний үндсэн эрх, ялангуяа нийгмийн эмзэг бүлгийнхний эрхийг хамгаалах тал дээр дутагдалтай ажиллах явдал;
- Уул уурхайн компаниудад олон нийтийн хөгжлийн талаарх ойлголт өгч, нийгмийн асуудалд анхаарлаа хандуулахыг дэмжих үйл ажиллагаа дутагдах явдал.

Уул уурхайн компаниуд эдгээр асуудлуудад анхаарахгүйгээр тухайн оронд үйл ажиллагаагаа амжилттай хэрэгжүүлэх боломжоо улам бүр алдах болоод байна. Тэгээд ч сүүлийн жилүүдэд улс дамнасан томоохон уул уурхайн компаниуд филантроп шинжийн нийгмийн үйл ажиллагаанд анхаарах болжээ. Тэдгээр үйл ажиллагаа нь тухайн орон нутгийн иргэдэд ашиг тустай байхаас гадна цаагуураа өөрсдийнх нь бизнесийн үйл ажиллагааг давхар дэмжиж байх ёстой (Imbun, 2007).

Бизнесийн нийгмийн хариуцлага

Судлаач Бөрд болон Смакер (Bird & Smucker, 2006) “бизнесийнхэн нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлэх ёстой гэдгийг ухамсарладаг боловч чухам ямар үйл ажиллагаа явуулах ёстой вэ гэдгээ тэр бүр мэддэггүй” гэжээ. Зарим судлаачид компаниуд бизнесийн ёс зүйг баримтлан, үйл ажиллагаандаа ил тод байх зарчмыг баримтлах нь нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлж буйн нэг хэлбэр гэж үздэг бол зарим нэг нь компаниуд хувь нийлүүлэгчдээ сайтар “тойлж”, хариуцлага гэдгийг өргөн хүрээнд буюу тухайн улс орны нийгэм, эдийн засагт оруулах хувь нэмрийн хэмжээгээр тодорхойлно гэж үздэг. Энэ мэтээр бизнесийн байгууллагын нийгмийн хариуцлагыг тогтоож болох авч тухайн байгууллагын үйл ажиллагааны хүрээ, ажиллаж буй орчин нөхцөл, орон нутгийн ёс заншил гэх мэт олон зүйлээс шалтгаалаад хариуцлагын хүрээ янз бүр байж болох юм. Судлаач Инбум (Imbun, 2007) нийгмийн хариуцлага гэдэг нь уул уурхайн компаниудын хувьд тухайн орон нутгийн байгалийн анхдагч байдлыг хөндөж, иргэдийн эрүүл амьд явах эрхийг нь эрсдэлд оруулж байгаагийн хариу болгож компаниудаас зайлшгүй боловсруулж, хэрэгжүүлэх төлөвлөгөө гэж үзжээ. Цаашилбал нийгмийн хариуцлагын хэрэгжилтийг олон улсад тогтоосон дүрэм, журмын дагуу дүгнэх үү, тухайн орон нутгийн иргэдийн санал бодолд түшиглэн дүгнэх үү гэдэг нь бодууштай асуулт юм.

Шигтгээ 1: Бизнесийн нийгмийн хариуцлага нь компаниудаас тухайн орон нутгийн эдийн засгийн, эрх зүйн, ёс суртахууны, нийгмийн нөхцөл байдал болоод хүрээлэн буй орчинд бодитоор оршин буй биет зүйлсийг задлан шинжилэхийг шаарддаг (Kapelus, 2002)

Шигтгээ 2: “...Хувь хүн, бүлэг, олон нийтийн сайн сайхны төлөө тухайн орон нутагт тулгараад буй эдийн засгийн, нийгмийн болоод байгаль орчны асуудлуудыг илрүүлэн шийдвэрлэх тэнцвэрт хандлагыг нийгмийн хариуцлага гэнэ...” (International Institute for Sustainable Development, 2004)

Судлаач Бөрд болон Смакер (Bird & Smucker, 2006) Ази, Африк, Өмнөд америкийн олон орныг дамнасан судалгааныхаа дүнд бизнесийн байгууллагууд амжилттай ажиллахад дараах зүйлсийг анхаарах хэрэгтэй гэдгийг сануулсан байдаг. Үүнд:

1. Бизнесийн үйл ажиллагаа явуулж буй тухайн орон нутгийн талаар гүнзгий мэдээлэлтэй, орон нутгийн иргэдийн аж байдал, ёс заншилтай танилцсан байх;
2. Үйл ажиллагааны талаарх мэдээллээ аль болох өргөнөөр түгээхийн сацуу орон нутгийн иргэдийн зан заншил, амьдралын хэв маягийг гутаан доромжилсон байдлаар харилцахгүй байхыг туйлаас хичээх. Өөрөөр хэлбэл зөв харилцаа тогтоох;
3. Тухайн орон нутгийн эдийн засгийн болоод нийгмийн өмчийг нэмэгдүүлж чадахгүй юм гэхэд сүйтгэхгүй байх.

Дээр дурдсанчлан компанийн нийгмийн хариуцлагын хүрээ нөхцөл байдлаас шалтгалаан янз бүр байж болох ч эдгээр гурван зүйлийг ямар ч компани дагаж мөрдөх шаардлагатай гэдэгтэй судлаачид санал нийлжээ.

Үйл ажиллагаа явуулж буй тухайн орон нутгийн талаар мэдээлэлтэй, орон нутгийн иргэдийн аж байдал, ёс заншилтай танилцсан байхын ач холбогдол

Гурван зуу гаруй байгууллагыг эгнээндээ нэгтгэсэн Интерфэйт Нийгмийн Хариуцлагын Төв болон Олон улсын Нийгмийн Хариуцлага гэх мэт томоохон байгууллагууд хамтран бизнесийн үйл ажиллагаа хариуцлагатай байгаа эсэхийг дүнгэх шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулсан байдаг. Бизнесийн байгууллагууд, тэр дундаа байгаль орчинд хийгээд тухайн орон нутгийн иргэдийн амьдралд нөлөө бүхий химийн бодис үйлдвэрлэгчид, модны үйлдвэрлэл эрхлэгчид болон томоохон уул уурхайн компаниуд аль ч улсад ялгаагүйгээр буюу түгээмлээр дагаж мөрдөх хариуцлагын ерөнхий зарчимтай байдаг. Аль ч улсад ялгаагүйгээр нэгдсэн зарчмыг дагаж мөрдөнө гэдэг нь тухайн улс орны хууль эрх зүйн систем бүрэн бүрэлдэж тогтоогүй юмуу хууль хэрэгжүүлэгч агентлагууд, иргэд нь мэдлэг мэдээллээр хомс байсан ч ялгаагүйгээр салбарынхаа хариуцлагын ерөнхий зарчмыг баримтлан ажиллана гэсэн үг юм. Гэхдээ бидэнд дагаж мөрддөг ерөнхий зарчим бий хэмээн тухайн орон нутгийн нийгэм, эдийн засгийн өвөрмөц байдал, оршин суугчдын аж байдлыг харгалзахгүйгээр “туйлширсан буюу модон” шийдвэр гаргаж болохгүй юм. Эгчид нь зориулан хийсэн цамц эрэгтэй дүүд нь таарахгүйтэй нэгэн адил олон улсад дагаж мөрдөх зарчмын жишиг тухайн орон нутгийн нөхцөл байдал, иргэдийн ахуй амьдралд нийцэхгүй байж болох талтай. Тиймээс ч бизнесийн, тэр тусмаа уул уурхайн компаниуд нийгмийн хариуцлагаа тодорхойлохдоо үйл ажиллагаа явуулж буй орон нутгийн захиргааны байгууллагууд болон иргэдтэй нягт хамтын ажиллагаатай байж тэдний дуу хоолойг сайтар сонсож үйл ажиллагаандаа тусгах хэрэгтэй юм. Тухайлбал Маргарет Грис (2007) “Компанийн нийгмийн хариуцлагыг тодорхойлоход Бразил улсын газар зүйн, улс төрийн болоод эдийн засгийн нөхцөл байдлыг харгалзах нь” бүтээлдээ Бразилын бүс нутгуудыг хүн амын тархац, аж байдлаар нь ангилан ялгаж эдийн засгийн хөгжлийг нь тоймлон бичсэнээс гадна хувь хүний зан үйлийг бүрэлдэн тогтоход нөлөөлдөг нийгмийн хэвшмэл ойлголтууд, үзэгдлүүдэд дүн шинжилгээ хийсэн байдаг. Мөн тэрээр тус улсын ядуурлын нөхцөл байдал, орлогын тэгш бус хуваарилалтын талаар бичиж Бразилд бизнесийн үйл ажиллагаа эхлүүлэх гэж байгаа байгууллага тус нийгэмд хүнийг арьс өнгө, гарал үүслээр нь ялгаварлан гадуурхаж харьцдаг түгээмэл хандлага байдгийг эхнээсээ анхаарах шаардлагатайг ч дурдсан байна. Энэ бүхэн нь нэгэн бодлын бизнесийн байгууллагад хамаагүй мэт санагдавч үйл ажиллагаагаа амжилттай явуулахыг хүсч байгаа байгууллага жижиг гэлтгүй хүн амын дундах нийгмийн хэвшмэл үзэгдлүүд, зан заншлыг анзаарахгүй байхын аргагүй юм. Ингэж чадаж гэмээ нь тухайн байгууллага орон нутгийн иргэдийн итгэлийг хүлээсэн байгууллагуудын нэг болж тухайн орон нутгийн онцлогт тохирсон үйл ажиллагаа явуулж чадна.

Орон нутгийн иргэд, захиргаатай зөв харилцаа тогтоохын ач холбогдол

Бизнесийн байгууллага орон нутгийн засаг захиргаа, оршин суугчидтай мэргэжлийн, нээлттэй, харилцан бие биенээ хүндэтгэсэн, зөв харилцаа үүсгэх нь тухайн орон нутгийн онцлогийг сайн танихтай нэгэн адил ач холбогдолтой юм. Олонх компаниуд үйл ажиллагаа явуулж буй газар нутагт амьдарч буй иргэдийн зан заншил, хэвшсэн амьдралыг гутаан доромжлохгүй юм гэхэд үл ойшоосон байдлаар хандах нь нэг талаар эрх мэдлээрээ түрүү барьж далайлгасан (abuse of power) явдал юм. Нөгөө талаар орон нутгийн захиргаа гадны байгууллагын хөрөнгө оруулалтад татагдан тэднийг хаан мэт хандан хэлсэн бүхнийг нь биелүүлдэг явдал энэ мэтээр компаниудыг эрх мэдлээрээ түрүү барих нөхцлийг нь бүрдүүлж өгч байдаг. Учир нь олон уул уурхайн компаниуд тухайн орны Засгийн газраас орон нутагт хийж чадаагүй, хүч хүрээгүй эдийн засгийн, улс төрийн болоод нийгмийн шинжтэй асуудлууд руу орж өөрсдөдөө нэмэлт ачаа үүрэн тухайн орон нутгийн олон нийттэй ажиллаж байгаа нь үнэн. Төрөөс үзүүлэх үйлчилгээ хүртээмжтэй, чанартай байж чадахгүй байгаа ийм нөхцөлд олон нийт ч уул уурхайн томоохон төслүүд орон нутагт нь хэрэгжиж эхлэхэд (асуудал үүсч эхлээгүй байхад) эхэндээ дуртайяа хүлээн авах хандлага бий. Ачаанаас үүрэлцэж буй ийм нөхцөлд засгийн газар уул уурхайн компаниудыг нийгмийн хариуцлагаа хэрхэн биелүүлж байгааг хянах, буруушаах, шүүмжлэхэд нэгэн бодлын бэрхшээлтэй болж байгаа юм.

Уул уурхайн компаниуд нийгмийн хариуцлагын стратегитэй байдаг. Гэсэн хэдий ч компаниуд тэрхүү цаасан дээр бичигдсэн зүйлсийг улс орон бүрт ялгаагүйгээр ягштал мөрдөх нь үгүй. Энэ тохиолдолд хөгжингүй орны иргэдийн дуу хоолой, санал хүсэлтийг илүү харгалзаж үзээд буурай хөгжилтэй орны иргэдийн хүсэлтийг үл ойшоох, түр аргацаах тохиолдлууд олон гардаг. Түүнээс гадна компанийн нийгмийн хариуцлагын төлөвлөгөө нь нэг талаар улс төрчдийн сонгуулийн үед боловсруулдаг мөрийн хөтөлбөртэй ижил юм. Нийгмийн хариуцлагын төлөвлөгөө боловсруулахад өмнөө тавих гол асуултын нэг бол “хэрхэн тухайн

орон нутгийн байгууллага, олон нийтийн итгэлийг даасан, тэдэнтэй сайн харилцаатай компани болох вэ?” гэсэн асуулт юм.

“Олон нийт” хэмээх ойлголт нь уул уурхайн компаниудын хувьд шинэ тутам яригдах болсон ойлголт бишээ. Энэ ойлголтыг “үйл ажиллагаа явуулж буй орны ёс заншил” гэсэн ерөнхий категорит багтаадаг байсан байна. Ер нь олзворлох үйлдвэрлэлийн хувьд ёс заншил нь хөгжлийн тушаа, үйл ажиллагаа явуулахад саад болж байдаг зүйл, ёс заншлаас үүдэн олон нийт уурхайн үйл ажиллагааг эсэргүүцдэг гэх мэт таагүй ойлголттой байдаг. Тийм ч учраас энэ мэт сөрөг үр дагаварыг бий болгохгүйн тулд тухайн компани олон нийт, иргэдээс албан бус “зөвшөөрөл” урьдчилан авсанаар үйл ажиллагаагаа саадгүй эхлүүлж болно гэж үзэх болсон (Kapelus, 2002). Монголд уул уурхай эрхэлж буй компаниудын хувьд одоогоор орон нутгийн иргэдтэй урьдчилан зөвшилцөх туршлагыг ашигладаггүй бөгөөд харин ч эсрэгээрээ олон нийтийг “задлах”, байгаль орчин иргэдийн аюулгүй байдлын төлөө үг дуугардаг идэвхтэй нэгнийг мөнгөөр, эд хөрөнгөөр амыг нь таглаж сурсан байдаг¹. Тэгээд ч бусад аймгаас шилжиж ирсэн малчид тэр бүр тухайн орон нутгийн уугуул иргэдтэй нэгдэн компаниудын эсрэг үг дуугарах нь ховор.

Тухайн орон нутгийн эдийн засгийн болоод нийгмийн өмчийг нэмэгдүүлж чадахгүй юм гэхэд сүйтгэхгүй байхын ач холбогдол

Бизнесийн нийгмийн хариуцлагын өөр нэгэн амин чухал хэсэг бол орон нутгийн иргэдийн сайн сайханд чиглэсэн үйл ажиллагаа юм. Үүний тулд бизнесийн байгууллага нь тухайн орон нутаг дахь эдийн засгийн болоод нийгмийн баялагийг шуналтайгаар хэрэглэж дуусгах бус харин ч шууд болон шууд бус байдлаар тэдгээрийг баяжуулж байх хэрэгтэй. Тухайлбал бизнесийн байгууллага орон нутгийн захиргаанд татвараа үнэнчээр төлөхөөс гадна орон нутгийн захиргааны хөрөнгө төсөв дутмаг үед дэд бүтцийг хөгжүүлэх, нийгмийн үйлчилгээ, албан бус боловсролыг сайжруулах санал санаачлагад идэвхтэй оролцох хэрэгтэй юм. Нийгмийн хариуцлагын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд хүмүүст “загас барьж өгөх бус харин хэрхэн загасчлах аргыг нь заах”-д анхаарах бөгөөд үүний үр дүнд орон нутаг, тухайн бүлэг хүмүүсийн амьдралд тогтвортой өөрчлөлтийг авч ирж чадах юм.

Олонх хөгжиж буй орны иргэд уул уурхайн компаниуд нийгмийн хариуцлагынхаа хүрээнд голдуу зам гүүр засах, нийтийн бие засах газар барих, сургууль, боловсролын төв барих гэх мэт нийгмийн дэд бүтцийг хөгжүүлэх үйл ажиллагаа явуулаасай гэж хүсдэг байна (Inbum, 2007). Цаашлаад тэд уул уурхайн компаниуд өдөр тутмын амьдралд хэрэгцээтэй зүйлийг ч хангаж байх нөхцлийг бүрдүүлсэн байх ёстой гэсэн хэтэрхий бэлэнчлэх бодол тээх нь ч бий. Энэ мэт хүслийг нь тэр бүр биелүүлэхгүй бол уул уурхайн компаниуд руу халдах, жагсаал цуглаан зохион байгуулах гэх мэтээр үйл ажиллагааг нь эсэргүүцэж эхлэх нь олонтаа тохиолдоно. Тиймээс компаниуд ямартаа ч нийгмийн хариуцлагын төлөвлөгөөтэй байх хэрэгтэй юм байна гэсэн байдлаар хайнга хандах бус тухайн орон нутгийн иргэдэд ямар аргаар бэлэн засаг барьж өгөх бус засагчлах аргыг нь зааж өгөх вэ гэдгийн нухацтай бодож, олон нийттэй хамтран төлөвлөгөө зохиох шаардлагатай болж байгаа юм.

Олон нийтэд ийнхүү анхаарал тавьж тэднийг хүндэтгэхээс өөр аргагүй юм. Учир нь уул уурхайн үйл ажиллагаанаас үүдэн тэдний хүрээлэн буй орчин бохирдох, эрхэлж байсан аж ахуйгаа өөрчлөх, магадгүй бүр сууршиж байсан газраасаа нүүх хэрэг гарах гэх мэт бүхий л сөрөг үр дагаварыг олон нийт л үүрч байдаг. Үүнтэй уялдуулан 1998 онд Дэлхийн банкнаас Өмнөд Америкийн орнуудаар зохион байгуулсан цуврал хоёр бага хурлаас уул уурхайн компаниуд цаашид аливаа шийдвэрийг гаргахын өмнө үйл жиллагаа явуулж байгаа тухайн орон нутгийн уугуул иргэдтэй зайлшгүй зөвшилцөж байх, тэдний зан заншил, уламжлалыг хүндэтгэн харилцах ёстой хэмээн харилцан хүлээн зөвшөөрсөн байдаг (Kapelus, 2002). Нобелийн шагналт эдийн засагч Амартья Сен “Хөгжлийн түлхүүр-Эх чөлөө” (Sen, 1999) номондоо тухайн орон нутгийн иргэдийн ур чадварыг сайжруулж амьдралаа дэвжүүлэх боломж бололцоот нөхцлийг нь бий болгож өгөх нь хүмүүсийн бүтээлч сэтгэхүйг дэмжих улмаар орон нутгийн биет болоод нийгмийн харилцааны нөөцийг нэмэгдүүлэх үйл ажиллагаа болно хэмээн онцолсоныг компаниуд болон засгийн газарууд үйл ажиллагаандаа ашиглах хэрэгтэй юм.

Олон нийтийг тодорхойлох нь, тэдний хөгжил

Ямар ч уул уурхайн компанийн хувьд нийгмийн хариуцлагын төлөвлөгөөг хэрэгжүүлэхийн тулд үйл ажиллагааны үр дүнг хүртэгчид буюу “олон нийт”-ээ тодорхойлох

¹ “Оюу Толгой Хяналт” ТББ-ийн Тэргүүн Д. Сүхгэрэлтэй хийсэн ярилцлагаас


шаардлага гарна. Гэхдээ олон нийтийг тодорхойлох тийм ч амаргүй. Зарим оронд олон нийтийг орлосон буюу толгойлсон дарга, зайсан, ахлагчаас зөвшөөрөл авсанаар тухайн олон нийтэй зөвшилцөлд хүрлээ гэж үзэж болдог байхад өөр бусад орны хувьд тухайн олон нийтийг амьдарч буй газар нутгийн хил хязгаараар, нийтээр дагах ёс заншилаар нь, шашин шүтлэгээр нь гэх мэт олон зүйлийг харгалзан тодорхойлох болдог. Эсвэл тухайн олон нийт өөрсдийн бий болгосон буюу нийтээрээ хүлээн зөвшөөрсөн онцлог шинжээрээ бусдаас ялгарч байж болох юм. Олон нийтийг тодорхойлоход амаргүй байдгийн бас нэгэн шалтгаан нь тэд нэг газартаа тогтвор сууршилтай байнга амьдардаггүй, нийгмийн нөлөөллөөр дагах ёс заншил, зан үйлээ өөрчилж болдог.

1975 онд АНУ-ын Үндэсний Судалгааны Зөвлөлөөс олон нийт гэдэг нь хоорондоо ойрхон амьдарч нийтлэг сонирхлоороо нэгдэн нийлж бие биедээ тусалж дэмжиж байдаг бүлэг хүмүүсийг хэлнэ гэсэн байдаг. Үүний дараа Филипс ба Питтман (Phillips & Pittman, 2009) нар газар нутгийн хувьд ойролцоо газар амьдарч өөр хоорондоо болон нутаг устайгаа нийгмийн болоод сэтгэл зүйн холбоо хамааралтай оршин амьдарч буй бүлэг хүмүүсийг олон нийт гэнэ хэмээн тодорхойлсон байдаг. Энэ мэт тодорхойлолтууд нь олон нийт гэдэг нь зүгээр нэг бүлэг хүмүүс биш бөгөөд тэдний хооронд ямар нэгэн холбоо хамаарал, ээнэгшил байдаг бөгөөд тэд тодорхой нэг газар нутагт амьдардаг гэсэн түгээмэл ойлголтыг бидэнд өгч байгаа юм. Харин олон нийтийн хөгжил гэдэг нь тухайн орон нутгийн иргэдийн амьдралын чанарыг сайжруулах зорилгоор иргэдийн чадавхийг нэмэгдүүлж бодит үр дүнд хүрэхэд чиглэсэн төлөвлөгөөт үйл ажиллагаа юм. Олон нийтийг хөгжүүлэх үйл ажиллагааны бодит үр дүн нь нийтийн биет хөрөнгө, нийгмийн, санхүүгийн болон байгаль орчны эрүүл аюулгүй байдал зэргээр илэрч болдог (Phillips & Pittman, 2009). Энэ чиглэлээр бичигдсэн ном, бүтээл, эрдмийн ажлуудад дараах дөрвөн төрлийн зүйлээр олон нийтийн хөгжлийг хэмжиж болох талаар дурдсан байдаг. Эдгээр нь:

1. Нийгмийн нөөц буюу хүмүүн капитал. Энэ нь тухайн олон нийтийн дунд хөдөлмөрлөх чадвартай хүмүүсийн харьцаа, тэдний ур чадвар, боломж, хуримтлуулсан туршлага гэх зэргээр илэрхийлэгдэнэ.
2. Биет хөрөнгө. Тухайн орон нутаг дахь дэд бүтцийн хөгжил, гудамж барилга байгууламжийн хүртээмж, тэдрээрийн чанараар илэрхийлэгдэнэ.
3. Санхүүгийн хөрөнгө. Энэ нь тухайн газар нутагт байрлах санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагаа, олон нийтэд жижиг зээл авах боломж байдаг эсэх, олон нийтэд түшиглэсэн хөрөнгийн нөөц сантай эсэхээр илэрхийлэгдэнэ.
4. Байгалийн нөөц, хөрөнгө. Энэ нь байгалын нөөц баялаг, уур амьсгалын нөхцөл байдал нь тав тухтай амьдрах, аж ахуйгаа эрхлэх нөхцлийг бүрдүүлж байгаа эсэхээр тодорхойлогдоно.

Эдгээр дөрвөн зүйлийн дотроос нийгмийн нөөц буюу хүмүүн капиталгүйгээр олон нийтийг төсөөлөх тун бэрх юм. Хүмүүн капитал сайтай байхад бусад гурван төрлийн хөрөнгийг нөхөх, баяжуулах боломжтой юм. Үүнээс гадна тухайн олон нийт өөрсдийн санаачилгаар зохион байгуулалтанд орж, өөрсдийн нөөц бололцоог дайчлах чадвартай байх нь тун чухал. Үүнийг судлаачид нийгмийн капитал буюу нийгмийн чадавх (social capital, social capacity) гэсэн ойлголтоор тайлбарлах бөгөөд энэ нь тэдний хувьд нийтээрээ хүлээн зөвшөөрсөн зорилгодоо хүрэх замыг шулуутгах, олон нийтийн хөгжлийг түргэсгэх бас нэгэн түлхүүр ойлголт юм. Олон нийт нийгмийн капитал, нийгмийн чадавх сайтай байх нь тэдний дундах харилцааг бататгаад зогсохгүй аливааг хамтран хийх, тулгарсан асуудлыг шийдвэрлэх, хамтын шийдвэрт хүрэх, төлөвлөгөө зохион зорилгодоо хүрэх алхамуудыг гүйцэтгэх гэх мэтээр хамтын хүчээр аливааг амархан хийж сурах давуу талтай.

Иймээс олон нийтийг хөгжүүлэх санал санаачлагууд нь хэрхэн тэдний нийгмийн капитал, чадавхийг сайжруулах вэ гэдэгт онцгой анхаарах шаардлагатай байгаа юм. Доор үзүүлсэн зурагт олон нийтийн хөгжлийн гинжин хэлхээсийг дүрслэн үзүүллээ. Шулуун шугамаар холбогдсон хэсгүүд нэрлэсэн зүйлс бие биетэйгээ хэрхэн шууд холбоотой байж болохыг харуулна. Олон нийтийг хөгжүүлэх үйл ажиллагааны эцсийн үр дүн буюу амжилт нь эргээд нийгмийн капитал ба хөгжүүлж олон нийтээс өөрсдөөс нь санал санаачлага гарахад нөлөөлж байдаг тул энэ холбоосыг тасархай шугамаар үзүүллээ.



Эх үүсвэр: (Philipps & Pittman, 2009)

Энэ мэт олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн ойлголтуудыг уул уурхайн компаниуд ашиглан нийгмийн хариуцлагын төлөвлөгөөгөө боловсруулбал тухайн орон нутгийн олон нийтийн хөгжилд тогтвортой хувь нэмэр оруулж чадах юм. Амжилт өөрөө амжилтыг дагуулдаг тул жижиг гэлтгүй санаачлагаас гарсан амжилт олон нийтэд урам зориг өгч дараа дараагийн алхамыг төлөвлөх, гүйцэтгэх урамаар дүүрэн болдог (Philipps & Pittman, 2009).

Гэтэл бизнесийн байгууллагууд нийгмийн хариуцлагын төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд аль болох бага хөрөнгө төсөвлөхийг хичээдэг нь нууц биш юм (Kapelus, 2002). Тиймээс ч олон нийтийг аль болох цөөхөн хүнээр төлөөлүүлж, хязгаарлагдмал хүрээнд олон нийтээ сонгож авах нь тэдэнд ашигтай. Байгаль орчны үнэлгээ хийгдэх болоход олон нийтийг цөөхөн хүнээр төлөөлүүлсэн байх нь мөн компаниудад ашигтайгаар эргэх сайн талтай. Учир нь байгаль орчны үнэлгээгээр тухайн орон нутгийн иргэдийн санал гомдлыг харгалзах тул компаниуд хэдий цөөн олон нийттэй харилцана, төдий чинээгээр гомдол санал бага ирэх сайн талтай шүү дээ.

Улс дамнасан корпорациудын нэр хүнд, хөрөнгийн хэмжээ, үйл ажиллагааны далайц нь олон улсыг хамарсан байдаг боловч яг тухайлсан буюу уул уурхайн үйл ажиллагааны тухай яригдаж эхлэхэд ажиллагааны далайц илүү орон нутгийн шинжтэй болж нэг ёсондоо “доошоо бууж” ирдэг онцлогтой. Учир нь тухайн компани орон нутгийн хөрснөөс, баялаг, байгал цаг уурт нь тохирсон техник технологи ашиглан, зарим тохиолдолд орон нутгийн иргэдээс ажилтнуудаа бүрдүүлэн үйл ажиллагаагаа явуулах тул орон нутгийн чанартай зүйлсээс бултах ямар ч гарцгүй болох нь тодорхой. Үүний нэгэн жишгээр Улс дамнасан корпорациудын нийгмийн хариуцлагын төлөвлөгөө төвөөсөө маш ерөнхий агуулгатай боловсруулагдан гарах бөгөөд үүнийг тухайлсан орон нутагт үйл ажиллагаа явуулах компани илүү нарийсгаж, харилцах олон нийтээ зөв зүйтэй тодорхойлж тэдний хүсэл эрмэлзэлд тохирсон болгож боловсруулах ёстой юм.

Хүний эрхийг хүндэтгэнэ, олон нийтийн оролцоог дэмжинэ гэх мэт ганган үг хэллэгээр дүүрсэн төвийн барим бичгийг орон нутгийн шинжтэй болгоно гэдэг нь гэвч тийм амар ажил бишээ. Энэ ажлыг Гротер ба Арас (Grother & Aras, 2008) нар “орон нутгийн онцлогийг тусгасан дэлхийн түвшиний төлөвлөгөө боловсруулах урлаг” гэж нэрлээд энэ урлагаас суралцахын тулд орон нутгийн олон нийтийг анхаарлын төвдөө байлгаж тэдэнтэй ойр хамтран ажиллах зайлшгүй хэрэгтэй бөгөөд ингэж чадвал тухайн компанийн байр суурь олон нийтийн дунд олон жил хамт амьдарч өөриймшсэн “местний Орос”-ын дайтай дотно болж чадна гэж үзжээ. Олон нийтийг чадваржуулж, хөгжүүлэн хэрэгцээт мэдээллээр нь хангаж өгвөл тэд улс орны хөгжлийн үйл явцад үнэтэй хувь нэмэр оруулж чадах найдвартай бүлэг байдаг. Учир нь олон нийт тухайн орон нутгийн онцлогийн талаар маш үнэтэй мэдээллийг өгч чадах бөгөөд ингэснээр төрийн үйлчилгээ болоод олон улсын байгууллагын тусламж эзнээ олж олон нийтээр дамжуулан орон нутагт тулгараад буй асуудлыг зөв илрүүлэн шийдвэрлэх боломжтой юм.

Сүүлийн жилүүдэд тогтвортой хөгжлийн тухайн ухагдахуун газар авч орон нутгийг, олон нийтийг тогтвортойгоор хэрхэн хөгжүүлж болох тараар онолын болоод практик үзэл баримтлалтууд их дэлгэрч байна. Засгийн газар, олон улсын байгууллагууд, төсөл хөтөлбөрүүд, нутгийн удирдлагуудаас зохион байгуулж буй ажлууд голдуу тухайн үед бий болсон асуудлыг хөрөнгө цохин шийдвэрлэхэд голлон анхаарахаас биш асуудлын цаана олон нийтийн эрх ашиг хэрхэх вэ? ийнхүү шийдвэрлэх нь нутгийн олон нийтэд мөн тэдний үе хойчид ямар үр нөлөө үзүүлэх вэ? гэх мэтээр хойчийг харсан холч ухаантай шийдвэрүүд байж тэр бүр чадахгүй л байна. Хөгжингүй улс орнуудад аливаа төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ тогтвортой хөгжлийг хангах үндсэн зарчмууд болох нийгэмд үзүүлэх үр нөлөө, байгаль орчинд үзүүлэх нөлөө болон эдийн засагт үзүүлэх нөлөөллийг заавал урьдчилан тооцож үздэг. Тэгвэл уул

уурхайн компаниуд маань тухайн орон нутгийн иргэдийг компанийн нийгмийн хариуцлагын төлөвлөгөөг боловсруулах, хэлэлцэх үед оролцуулах нь олон нийтийн тогтвортой хөгжилд оруулах хувь нэмэр болж чадах юм. Ийнхүү оролцсоноор олон нийтийн сэтгэн бодох, аливаад шүүмжлэлтэй хандах, харьцуулах гэх мэт сэтгэн бодох чадвар нэмэгдэх бөгөөд энэ нь зөвхөн нэг удаагийн хэлэлцүүлгээс цааш тэдэнд болон үр хүүхдэд нь үлдэх чадвар болж болох юм.

Түүнчлэн уул уурхайн компаниуд орон нутгийн иргэдэд зориулан сургалт зохион байгуулахдаа тэдэнд бид зааж өгөх ёстой гэсэн байр сууринаас бус харин “тэднийг сонсоё, тэдэнтэй хамтран зохион байгуулья, тэднээр сургалтын энэ хэсгийг хөтлүүлье” гэх мэтээр хамтрах нь мөн л уламжлал болсон сургалтын арга барилаас илүү үлдэцтэй буюу олон нийтийг чадварыг нэмэгдүүлэхэд чиглэсэн хандлага болох юм.

Монгол дахь уул уурхайн компаниуд ба олон нийтийн хөгжлийн нөхцөл байдал

Өнөөдөр Монголд Байгаль орчны иргэний зөвлөлийн гишүүн төрийн бус байгууллага (ТББ)-ууд, бусад бие даасан ТББ-ууд болоод унаган байгальдаа, бас ч үгүй нутгийг малчдын амьдралд сэтгэл зовнисон хувь хүмүүс уул уурхайн компаниудын үйл ажиллагаанд хяналт тавин ажиллаж байна. Тэдгээрийн олонх нь уул уурхайгаас үүдсэн орчны бохирдол, байгаль орчин, усны нөөцийн хомсдол, бохирдолын эсрэг үйл ажиллагаагаа явуулж байгаа бол цөөнгүй хэд нь олон нийгэд тулгамдаад буй нийгмийн шинж чанартай асуудлуудыг шийдвэрлэхэд тус нэмэр болох зорилготойгоор ажиллаж байна. Уул уурхайн үйл ажиллагаанаас тухайн орчинд амьдарч буй малчид хамгийн ихээр хохирч үлддэг. Компаниуд малчдын бэлчээрийг булаан, айлуудыг нүүхээс өөр аргагүй байдалд оруулах нь энүүхэнд. Улмаар уурхайн ухсан нүхэнд малчдын мал унаж үхэх, бохирдсон усаар ундаалж хордох зэрэг тохиолдлууд гарах бөгөөд энэ мэт зүйлээс болж малчид үе залгамжлан амьдарч дассан нутгаа орхин нүүх, амьжиргааны эх үүсвэр болсон малаасаа салах явдал тохиолсоор л байна.

Монголд үйл ажиллагаа явуулж буй хэдхэн том уул уурхайн компаниуд нийгмийн хариуцлагын эсвэл тогтвортой хөгжлийн хөтөлбөртэй боловч дунд болон жижиг уурхайнуудын олонх нь энэ талаар мэдэхгүй байсаар байна. Мэдсэн ч үүнийг өөрийн компанийн маркетингийн үйл ажиллагаатай хольж хутган иргэдэд бэлэг, хүнсний бүтээгдэхүүн тараах зэрэг үйл ажиллагааг нийгмийн хариуцлагаа маш сайн биелүүлж байна гэж үздэг. Гэтэл манайд үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн компаниудын хэд нь том хэд нь дунд болон жижиг уурхайнууд билээ? Орон нутгийн чанартай үйл ажиллагаа явуулдаг ТББ-уудын үзэж буйгаар компаниудад нийгмийн хариуцлагын төлөвлөгөө гэж байдаг боловч энэ нь зөвхөн цаасан дээр бичигдсэн үгс байдгаас амьдрал дээр тэр бүр хэрэгждэггүй гэнэ. Нийгмийн хариуцлагын төлөвлөгөөнөөс гадна эрүүл мэндийн нөлөөллийн байдлын үнэлгээ хийгдэх ёстой боловч энэ нь хийгддэггүй. Манайд энэ мэт үнэлгээ, төлөвлөгөөг боловсруулах нэгдсэн стандарт байдаггүй, дагаж мөрдөх зарчимын асуудал учир дутагдалтай тул компаниудыг ч зуун хувь буруутгах хэцүү мэт. Тухайлбал эрүүл мэндийн үнэлгээний үр дүнг хэрхэн зөвлөмж болгон гаргасан, тэдгээр зөвлөмж нь хэрхэн компанийн нийгмийн хариуцлагын төлөвлөгөөнд багтаж чадаж вэ гэдгийг хянах хяналт байдаггүй, хийгдсэн ажлууд нь хоорондоо уялдаа холбоо байдаггүй хэвээр¹.

Орон нутгийн иргэдэд зориулан зарим компаниас сургалт явуулах боловч энэ нь цөөн хүнийг хамарсан, бодит үр дүн муутай байдаг. Мөн орон нутгийн иргэдийг ажлын байраар хангаж байна гэх боловч энэ нь гол төлөв эрэгтэйчүүдэд зориулсан түр зуурын буюу богино хугацааны, цалин багатай, гэрээт ажлууд байдгаас үүдэн авсан цалингаараа амьжиргаагаа тогтвортойгоор залгуулах боломж нь бүрхэг болдог. Энэ мэт наад захын жишээнээс уул уурхайн компаниудын нийгэмд чиглэсэн үйл ажиллагаа нь түр зуурын шинжтэй бөгөөд иргэдийн нийгмийн асуудлыг тогтвортой байдлаар авч хэлэлцэх нь бүү хэл ажилчдынхаа нийгмийн асуудалд тэр бүр анхаардаггүй байна².

Мөн уул уурхайн компаниуд үйл ажиллагаагаа явуулж эхлэхийн өмнө тухайн орон нутгийн иргэдэд мэдээлдэггүй, нэг л өдөр газар ухаж эхэлдэг. Говь-Алтай, Баянхонгор, Увс, Завхан аймгийг хамарсан үйл ажиллагаа явуулдаг “Салхин Сандаг Холбоо” ТББ-ын Тэргүүн Ж. Түдэвдорж “бидний хойч үе амьдрах газаргүй болж байна. Хүн таван цул эрхтэнгүйгээр амьдарч чадахгүй. Тэгвэл алт, зэс гэх мэт эрдэс баялаг, ус, газрын тос дэлхийд ямар хэрэгтэй юм бэ? Тэдгээрийг юу ч үгүй шунахайгаар хэрэглээд дуусчихвал юу болох вэ?” гэсэн асуултыг

¹ Оюу Толгой Хяналт ТББ-ын Тэргүүн х. Д. Сүхгэрэлтэй хийсэн ярилцлагаас

² “Ариун Суварга” ТББ-ын Тэргүүн н. Чагнаадоржтой хийсэн ярилцлагаас. Тус ТББ Архангайн 10-аад сум, Өвөрхангайн гурван сумыг хамарч үйл ажиллагаа явуулдаг.

бид бүхэнд тавьлаа. Үүнээс бид байгалийн баялагийг огт ашиглаж болохгүй биш харин зөв зохистой ашиглаж, түүнтэй зөв харьцах ёстой бөгөөд байгалийн баялаг ашиглалтын талаар аливаа шийдвэр гаргахад тухайн газар нутагт он удаан жил амьдарч дассан хүмүүсийг оролцуулж, зөвшилцөж байх хэрэгтэй гэдгийг ойлгох ёстой юм. Өнөөдөр энэ чиглэлээр буюу засгийн газар, уул уурхайн компаниуд болон иргэдийн хооронд зөвшилцөл хийдэг болгох гэх мэт бизнес, нийгмийн, олон нийтийн үйл ажиллагааг хослуулдаг болох нааштай алхамууд хийгдэж эхэлсэн боловч бодит үр дүнд хүрэх нь хэзээ бол?

Харин орон нутагт олон нийтийн хөгжлийн түвшин доогуур хэвээр байсаар байна. Олон нийтийг хөгжүүлэх олон улсын байгууллагууд, төсөл хөтөлбөрүүд олноороо хэрэгжсээр байгаа хэдий ч олон нийтийн хөгжлийн суурь тэр бүр бат бөхөөр тавигдаж чадахгүй байгаагийн шалтгааныг ул суурьтай судлах хэрэгтэй болж байгаа юм. Олон нийт нэгдмэл санаатай байж, хамтдаа өөрсдийнхөө сайн сайхны төлөө ажиллаж чадахгүй байгаа нь аймагт өөр аймгаас шилжиж ирсэн суугуул иргэд уугуул иргэдтэй тэр бүр нэгдэн нийлж чадахгүй харин ч бэлчээр булаалдах, бие биенээ хавчиж шахах гэх мэтээр улам бүр асуудал үүсгээд байна уу? Үүнийг мэдэрсэн мэт тухайн нутагт үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн компаниуд олон нийтийг улам бүр задлах оролдлогууд хийдэг байна¹. Өөрөөр хэлбэл компаниуд тэдний эсрэг дуугардаг нэгнийг өөрийн ажилтнаар авах, хүүхдийг нь сургуульд суралцах тэтгэлэгт хамруулж өгөх, машин унаа өгөх гэх мэт амьжиргааны наад захын хэрэгцээг нь хангахуйц буюу татгалзахын аргагүй саналаар “амыг нь таглах” тохиолдол цөөнгүй бий. Байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээнд нийгэмд үзүүлж буй сөрөг нөлөөллийн талаар мөн олон нийтийн талаар ер дурдагдаагүй байдаг. Мөн тухайн орон нутагт олон нийтийг хэрхэн тодорхойлсон талаар мэдээлэл ч байдаггүй². Ийм нөхцөлд олон нийтийг хэрхэн жинхэнэ утгаар нь хөгжүүлэх вэ? Бид хэрхэн уул уурхайн компаниудыг жижиг том гэлтгүй нийгмийн хариуцлагаа ухамсарлан, орон нутгийн иргэдтэй хамтран ажилладаг, тэднийг сонсдог, тэдний хөгжилд оруулах хувь нэмрийг тогтвортой байдлаар хардаг болгох вэ?

Ашигласан материал

- Bird, F., & Smucker, J. (2007). The Social responsibility of international firms in developing areas. *The Journal of Business Ethics*, 73, 1-9.
- Greese, M. (2007). *The Geographic, economic and political context for corporate social responsibility for Brazil*. In social responsibilities of international business firms in developing areas by Bird, F., & Smucker, J. *The Journal of Business Ethics*, 73, 1-9.
- Growther, D., & Aras, G. (2008). *Corporate Social Responsibility*. Retrieved October, 2011, from www.bookboon.com
- Imbun, B.Y. (2007) *Cannot manage without “the significant others”*: Mining, corporate social responsibility and local communities in Papua New Guinea. Retrieved October, 2011, from www.jstor.com
- Kapelus, P. (2002). Mining, corporate social responsibility and the “community”: The case of Rio Tinto, Richards Bay Minerals and Mbonambi. *The Journal of Business Ethics*, 39 (3), 275-296.
- McPhail, K., & Davy, A. (1998). *Integrating social concerns into private sector decision making: A review of corporate practices in the mining, oil and gas sectors* (Report No384). The World Bank, Washington, D.C.: U.S.
- Phillips, R., & Pittman, R.H. (2009). A Framework for community and economic development. *An Introduction to community development* (pp.3-18). NY: Routledge.
- Sen, A., (1999). *Development as Freedom*. New York: Random House.

Ашигласан цахим хуудсууд

Интерфэйт Нийгмийн Хариуцлагын Төв- Interfaith Center for Social Responsibility

<http://www.iccr.org/>

Олон Улсын Бизнесийн Нийгмийн Хариуцлага Төв–Center for International Corporate Social Responsibility <http://wpweb2.tepper.cmu.edu/cicr/>

Тогтвортой Хөгжлийн ОУ-ын Институт–International Institute for Sustainable Development

¹ Оюу Толгой Хяналт ТББ-ын Тэргүүн х. Д. Сүхгэрэлтэй хийсэн ярилцлагаас

² “Хүний эрх хөгжил төв” ТББ-ын ажилтан х. Эрдэнэчимэгтэй хийсэн ярилцлагаас